

Хүний нөөц

1.1. Хүний нөөц, сургалт хөгжлийн алба жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт

Хүний нөөц сургалт хөгжлийн алба нь “НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”, “МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧТАЙ ХИЙСЭН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ, "НИЙСЛЭЛИЙГ 2022 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ"-нд хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн дагуу 2 бүлэг 20 зорилт, 46 чиглэлээр арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан БНЭМТ-ийн даргаар батлуулан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дундаж хувь 91.3% байна.

Хүний нөөцийг мэргэшүүлэх, Эрүүл мэндийн ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны ханган ажиллах зорилгын хүрээнд.

- ✓ Хүний нөөцийг мэргэшүүлэх 10 зорилтын хүрээнд 23 төрлийн мэргэжил дээшлүүлэн суралцуулах ажлыг төлөвлөж биелэлт 82,6 % биелэлттэй байна.
- ✓ Эрүүл мэндийн ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хангах, 10 чиглэлээр 22 ажил төлөвлөн, биелэлт 100%-ийн биелэлттэй байна.

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь 273 ор, 8 алба 14 тасаг нэгжтэйгээр дүүргийн болон Төв, Хэнтий аймгийн ойролцоох 8 сумдын хүн амд нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тооны стандарт MNS5095:2017-ын дагуу тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Хүний нөөцийн хувьд нийт 332 ажилтантай.

Үүнд:

- Их эмч 85
- Эм зүйч 2
- Халдвар судлагч их эмч 2
- Нийгмийн эрүүл мэндийн ажилтан - 2
- Биоанагаах судлаач 4
- Сувилагч, эмнэлгийн тусгай дунд мэргэжилтэн 132 /сувилагч 92, тусгай мэргэжилтэн 38/
- Туслах сувилагч 7
- Бусад дээд мэргэжилтэн 39
- Үйлчлэгч 36, бусад туслах үйлчилгээний ажилтан 24 ажиллаж байна.

Одоогийн байдлаар:

- 10000 хүн амд ноогдох их эмчийн тоо 25
- 10000 хүн амд ноогдох сувилагч, эмнэлгийн тусгай дунд мэргэжилтний тоо 50
- Нэг эмчид ноогдох сувилагчийн тоо 1,5 байна.

Эмч, Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн хувьд:

- Тэргүүлэх зэрэгтэй эмч 7
- Ахлах зэрэгтэй эмч 9
- Зөвлөх сувилагч 2

- Тэргүүлэх зэрэгтэй сувилагч дунд мэргэжилтэн 15
- Ахлах зэрэгтэй дунд мэргэжилтэн 38
- Эх барихуйн мэргэшлийн Тэргүүлэх-2
- Эх барихуйн мэргэшлийн Ахлах -6
- Лаборантын мэргэшлийн Ахлах -1
- Статисткч баг эмчийн Ахлах зэрэг-2,
- Эм найруулагчийн Тэргүүлэх зэрэг-1
- Эм найруулагчийн Ахлах зэрэг-2

• Халдвар судлагч бага эмчийн Тэргүүлэх зэрэг-1 болж эмч нарын 19,4%, дунд мэргэжилтнүүдийн Нийт 70 буюу 53% нь мэргэжлийн зэрэг хамгаалж мэдлэг мэргэжил ур чадвараа дээшлүүлсэн.

Боловсролын зэрэг цолны хувьд:

- Клиникийн профессор цолтой эмч 7
- Магистр эмч 17,

Сувилагч тусгай мэргэжилтэн:

132 сувилагч, тусгай мэргэжилтэн, 7 туслах сувилагч бүтэц орон тоогоор батлагдсанаас 124 сувилагч, тусгай мэргэжилтэн, 7 туслах сувилагч ажиллаж байна.

Үүнд:

- Сувилагч 90 буюу 68,5%
- Тусгай мэргэжилтэн 34 буюу 26,8%
- Туслах сувилагч 7 буюу 4,7%
- Магистр-1
- Бакалавр-36
- Диплом-87

Эмч нарын 89%, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн 52.4% нарийн мэргэжил эзэмшсэн. Нарийн мэргэжил шаардагдах ажил, албан тушаалын хангалт 90% байна.

Мэргэшүүлэх болон чадваржуулах сургалтанд хамруулж, мэдлэг мэргэжил, боловсролыг дээшлүүлж буй байдал:

Тайлант хугацаанд байгууллагад хэрэгцээ шаардлагатай, дутагдалтай байсан чиглэлээр эмч, сувилагч нарын сар бүрийн үндсэн цалинг олгон сургалтаа төгсөөд тус эрүүл мэндийн төвд 5-10 жил тогтвор суурьшилтай ажиллах хатуу гэрээ байгуулсан сургалтанд хамруулаад байна. Үүнд:

Мөн үндсэн мэргэжил олгох сургалтанд:

- Хүүхэд судлал- 1
- Дотор судлал - 2
- Дүрс оношилгоо судлал-1

- Мэдээгүйжүүлэг-1 зэрэг чиглэлүүдээр нийт 6 их эмчийг үндсэн мэргэжил олгох сургалтанд

Төрөлжсөн мэргэжил олгох сургалтанд:

- Сэтгэл засал-1
- Эх барих эмэгтэйчүүд судлал-1
- Эмэгтэйчүүдийн мэс засал судлал-1
- Хэвлийн хөндийн дурангийн мэс засал-1
- Хоол боловсруулах тогтолцооны судлал-1
- Хүүхдийн перинатал судлал-1
- Эх барих эмэгтэйчүүдийн дүрс оношилгоо-1
- зэрэг чиглэлүүдээр нийт 2 эмчийг төрөлжсөн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрууллаа.

Төрийн сангийн тэтгэлэгээр сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд төгсөлтийн дараахь

Нарийн мэргэжил олгох сургалтанд:

- Мэдээгүйжүүлгийн сувилахуй-1
- Гэмтлийн мэс заслын сувилахуй-1
- Дархлаажуулалтын сувилахуй-1
- Гемодиализын сувилахуй-1
- Төвлөрсөн ариутгалын ариутгагч-1
- Сэргээн засахын сувилахуй-1
- Эх барих судлал-1
- Эх барихуйн дээшлүүлэх-1


Төгсөлтийн дараах нарийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд нийт 8 сувилагч, тусгай мэргэжилтэн, сувилагч, тусгай мэргэжилтэнг сургалтанд хамруулсан нь Төгсөлтийн дараах мэргэшил олгох болон дээшлүүлэх сургалтанд **86** сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан нь нийт **74,7%** нь нарийн мэргэжил эзэмшсэн байна.

“Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол улсын эрүүл мэндийн сайд нийслэлийн засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчтай хийсэн хамтран ажиллах гэрээ, “нийслэлийг 2022 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө”-ний хүрээнд тус эрүүл мэндийн төвд үйлчлэгчээр ажиллаж байгаа туслах сувилагчаар 6 ажилтанг сурган бэлтгэн авлаа.

ГУИС-ийн дадлагажигч оюутнуудад хавар намрын уртын дадлагыг удирдамжийн дагуу арга зүйн зөвлөгөө өгч хүний нөөц сургалт хөгжлийн алба, халдвар хяналтын албатай хамтарч сургалтыг орж, төгсөөд ажиллахаар 7 сувилагчтай гэрээ байгуулсан.



Үйлчлэгээр ажиллаж байгаад ажилдаа хариуцлагатай ажилтан тул С.Шинэжилийг Аюултай хог хаягдалын ажилтаны сургалтанд байгууллагын зардлаар 100% сурган Аюултай хог хаягдлын ажилтанаар томилон ажиллаж байна.



Удирдлагын багын гишүүдийг мэргэжил ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор АШУҮИС-ын Эрүүл мэндийн удирдлага зохион байгууллалт чиглэлээр нийт 8 /ӨЭМТ-ийн 2 дарга/ ажилтан суралцаж байна.

Үндсэн мэргэжлийн сургалт эрхлэгч байгууллага болох зорилтын хүрээнд

Эмнэл зүйн сургагч багш бэлтгэсэн:

- Дотор
- Хүүхэд
- Эх барих эмэгтэйчүүд
- Мэс засал чиглэлээр сургалт эрхлэх байгууллага болох зорилгын хүрээнд Дотрын тасгийн эрхлэгч эмч Л.Чимэдлхам, ҮАЭОД /Мэс заслын их эмч/ С.Баатар-Уул, Эх барих эмэгтэйчүүдийн их эмч Б.Бадамханд, Нөхөн үржихүйн зохицуулагч эмч Л.Дэлгэрцэцэг, ЭЭОД /Хүүхэд, нярайн их эмч/ Н.Сэлэнгэсүлжээ нарыг



“ЭМНЭЛЗҮЙН СУРГАГЧ БАГШ”-ын сургалтанд хамруулан амжилттай дүүргэн сургагч багшийн гэрчилгээ гардан авсан.

Зэрэг цол нэмсэн

Глобал удирдагч их сургуулийг Эрүүл мэндийн бодлого удирдагч мэргэжилээр Төрөх нярайн тасгийн Эмэгтэйчүүдийн зөвөлгөө өгөх кабинетийн их эмч Б.Бадамханд, Эх барих эмэгтэйчүүдийн их эмч Ж.Мөнхномин нар нь магистрын зэрэгээ амжилттай хамгаалсан байна.



Мэргэжлийн зэрэг горилох шалгалтанд Сувилахуйн Тэргүүлэх зэрэг-2, Ахлах зэрэг-2, Эм баригчийн Тэргүүлэх зэрэг-1 амжилттай хамгааллаа.

- ✓ Монгол улсын сувилахуйн мэргэшлийн Зөвлөх -2
- ✓ Эмч ,сувилагч тэргүүлэх- 35
- ✓ Эмч сувилагч ахлах зэрэг-38
- ✓ Эх барихуйн мэргэшлийн Тэргүүлэх-2
- ✓ Эх барихуйн мэргэшлийн Ахлах -6
- ✓ Лаборантын мэргэшлийн Ахлах -1
- ✓ Статисткч баг эмчийн Ахлах зэрэг-1,
- ✓ Эм найруулагчийн Тэргүүлэх зэрэг-1
- ✓ Эм найруулагчийн Ахлах зэрэг-2 эмч, сувилагч тусгай мэргэжилтэн мэргэшлийн зэрэгтэй байна.

Туршлага судалсан байдал

- ✓ Хүний нөөцийг мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 10 дээд шатны Эрүүл мэндийн байгууллагатай хамтран 23 төрлөөр ажлын байрны дагалдан сургалт буюу туршлага судлан ажлын байран дээрээ ирж хэрэгжүүлэн ажиллаж байна.
- ✓ Нян судлалын лаборант Т.Уранцэцэг, А.Должин нар ХӨСҮТ-д 14 хоногийн ажлын байрны дадлагжуулах сургалтанд хамрагдаж сүрьеэгийн лабораторид хавсран ажиллаж байна.
- ✓ Рентген техникч Батцэцэг Улсын 3-р төв эмнэлэгт КТГ-н 5 хоногийн ажлын байрны дагалдах сургалтанд хамрагдсан.
- ✓ Монголын Дурангийн холбоо, Мед-Импекс ХХК, Улсын 1-р төв эмнэлэгийн дурангийн эмч нарын хамтарсан хяналт үнэлгээ, дадлагжуулах сургалтанд дурангийн 1 эмч, 2 сувилагч хамрагдсан
- ✓ Сүрьеэгийн их эмч М.Солонгоог ХӨСҮТ-ийн Сүргэгийн тандалт судалгааны албанд ажлын байрны дагалдан сургалтанд 5 хоног хамруулах
- ✓ Улсын гуравдугаар төв эмнэлэг дээр Дүрс оношилгооны их эмч Б.Төгсжаргалыг Компьютер томографикийн дагалдан сургалтанд 7 хоног хамрагдуулах
- ✓ Эрэгтэйчүүдийн кабинетын их эмч Л.Мөнхбаярыг ажлын байрны 7 хоногын дагалдан сургалтанд хамруулах

- ✓ А.Даариймаа Эс судлалаар судлалын чиглэлээр ажлын байрны дагалдан сургалтанд 7 хоног хамруулах
- ✓ Улсын нэгдүгээр төв эмнэлэгийн Яаралтай тусламжийн тасагтай хамтран Түргэн тусламж 103 тасгийн эмч, хариуцлагатай жижүүрт эмч нарыг яаралтай тусламжийг тухай бүрт нь яаралтай авах мэргэшүүлэх чиглэлээр 2022 оны 1-р улиралаас эхлэн хамтран туршлага судлан ажиллаа.

АШУҮИС, Монгол Японы эмнэлэг нь “**Үйлчлүүлэгч дэмжих албаны үйл ажиллагааг танилцуулах**”, “**Холбогдох байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хамтран ажиллах**” туршлага солилцох уулзалтыг 2022-02-23 нд 321 тоот хурлын зааланд зохион байгуулсан.



- ✓ Уулзалтанд манай байгууллагаас ЭМТҮЧАБ-ын албаны аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер Г.Биндэръяа, өрхийн менежер С.Энхчимэг, сувилахуйн албаны дарга Б.Нарангэрэл, ахлах арга зүйч Б.Лхагва, арга зүйч Л.Отгонсүрэн, Д.Цэцэгмаа, үйлчилгээний албаны дарга Т.Алтанчимэг, Биваангирд ӨЭМТ-ийн эмч Ц.Цэвээндулам, Энэрэлт-Өлзий ӨЭМТ-ийн эмч Г.Энэрэлт нар оролцсон.
- ✓ Арга хэмжээний нээлтэнд АШУҮИС, МЯЭ-ийн захирал М.Адилсайхан, ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтсийн дарга С.Энхцолмон, эмнэлзүй эрхэлсэн дэд захирал М.Наранпүрэв, үйлчлүүлэгчийг дэмжих албаны дарга Д.Эрдэнэчимэг, ахлах сувилагч Л.Номин-Эрдэнэ, бусад ажилтнууд АШУҮИС, Монгол-Япон эмнэлгийн онцлог, үйлчлүүлэгчийг дэмжих албаны үйл ажиллагаа /2019-2022 он/, үйлчлүүлэгчийг дэмжих албаны өртөөчилсөн урсгалыг танилцуулах /эмнэлэгт хэвтэхийн өмнөх дэмжлэг, эмнэлэгт хэвтэх үеийн дэмжлэг, эмнэлгээс гаргах үеийн дэмжлэг, санал хүсэлт хүлээж авах, шийдвэрлэхэд оролцох, холбогдох байгууллагуудад мэргэжил арга зүйн санал солилцсон уулзалт болсон.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн “**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба**”-ны ажлын туршлага судлах үйл ажиллагааг 2022-05-05 ны өдөр Улсын хоёрдугаар эмнэлгийн ЭМТҮЧАБайдлын албаны өрөөнд зохион байгуулсан.

- ✓ Туршлага судлах үйл ажиллагааг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ЭМТҮЧАБайдлын албаны дарга З.Аръяасүрэн, чанарын менежер Б.Дулмаа,

чанарын лавлагаа мэдээллийн ажилтан н.Номин нар удирдан, өөрсдийн ажил, тасаг, нэгжийн онцлогоо танилцуулсан.

- ✓ Улсын хоёрдугаар төв эмнэлгийн чанарын менежер Б.Дулмаагийн хамт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, ерөнхий мэс засал, дүрс оношлогооны төв, цөмийн оношлогоо, эмчилгээний төв, нэгдсэн лабораторийн тасгуудаар явж ажлын явцтай нь биечлэн танилцаж, мэдээлэл солилцсон.
- ✓



- ✓ Туршлага судлах ажилд манай байгууллагын ЭМТҮЧАБайдлын албаны дарга, менежерүүд, лавлагаа мэдээллийн ажилтан нар багаараа явж чанарын албаны дотоод ажил, хяналт үнэлгээ, чанарын ажилтай холбоотой журмууд, чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартын хэрэгжилтийн талаар санал, бодлоо чөлөөтэй ярилцаж, цаашид хамтран ажиллахаар болсон.

Дотоод сургалтууд

Ажилчдыг мэргэжил, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөх эмч нарыг урьж хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

- Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Ерөнхий мэс заслын тасгийн эрхлэгч Н.Алтанчимэг
- ЭХЭМҮТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн их эмч клиникийн профессор Д.Болормаа
- Хуулийн зөвлөх Э.Алтан-Уяа
- Эмгэг судлалын зөвлөх эмч Х.Гэрэлээ
- Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн нийт эмч, сувилагч нарт лавшруулсан суурь тусламж үзүүлэх чадварыг сайжруулах зорилгоор ажлын байран дээрх сургалтыг нийт ажилчдад
- Насанд хүрэгчид амилуулах суурь тусламж
- Насанд хүрэгчдийн Амьсгалын зам чөлөөлөх, интубаци
- Монитор , эмийн эмчилгээ
- Дефибриляторын ашиглах , хэм шалгах
- Тархины цочмог цус хомсрох харвалтын яаралтай тусламж
- Цохиулах шаардлагатай хэм, эмийн эмчилгээ
- Цохиулах шаардлагагүй хэм, эмийн эмчилгээ /5Н, 5Т шалтгаан/

- Хүүхдийн амилуулах суурь тусламж
- Хүүхдийн амьсгалын зам чөлөөлөх, интубаци
- Амилуулах тусламжийн алгоритм хэрэглэх арга лекц
- Амилуулах тусламжийн гинжин хэлхээ лекц
- Мега кодоор шалгах сэдвээр сургалтыг авч ажиллаа.



Улсын нэгдүгээр төв эмнэлэгийн Яаралтай тусламжийн тасагтай хамтран Түргэн тусламж 103 тасгийн эмч, хариуцлагатай жижүүрт эмч нарыг яаралтай тусламжийг тухай бүрт нь яаралтай авах мэргэшүүлэх чиглэлээр 2022 оны 1-р улиралаас эхлэн хамтран ажиллаж байна. Дотрын их эмч, мэдээгүйжүүлэгийн их эмч, түргэн тусламжийн эмч нарын бүрэлдэхүүнтэй 2 багын нийт 6 эмч хамрагдсан байна.



➤ 2022 оны 05 дугаар сарын 28 өдөр ЭМЯ, БНЭМТ-ийн ёс зүйн хэсгийн хорооноос зохион явуулсан “Гамшигийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй”-н сургалтанд 241 эрүүл мэндийн ажилчид хамрагдсан.



➤ Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсээс зохион явуулсан “Таны эрх-Таны оролцоо” сэдэвт уулзалт өдөрлөгт Эрүүл мэндийн төвийн Ёс зүйн хэсгийн хороо хамтран ажилласан ба эрүүл мэндийн ажилчид хамрагдсан.



2022 оны 02 дугаар сарын 09 өдөр Амбулаторийн тасаг, Мэдрэлийн тасаг, Төрөлжсөн тусламж үйлчилгээний алба, Замбага хувийн эмнэлэгийн ажилчдад ЭМС-ын

2019 оны 09 дүгээр сарын 04 өдрийн А/406 тоот тушаал, “Эерэг хандлага”, “Хандлага”, “Эмнэлгийн мэргэжилтний эерэг харилцаа” сэдвээр суралцах сэдвээр сургалт хийсэн.



Ажлын байрны сургалтыг тогтмолжуулах чиглэлээр байгууллагын хэмжээнд сувилахуйн албанаас дотоод сургалтыг онол болон дадлагын хэлбэрээр хуваарийн дагуу 11 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 486 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдан мэргэжил ур чадвараа сайжруулсан байна.



2022 оны 10-р сарын 03-ний өдөр ЭМТҮЧА-наас “Унах эрсдлээс сэргийлэх” цахим сургалт зохион явуулсан.

Цахим эмнэлэг болох төлөвлөгөөний дагуу Медсофт v7 программбг 7 сарын 1нээс нэвтрүүлж 2022 оны 8-р сарын 4-ны өдрийн А/61 тоот тугаалын дагуу нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн хөтөлдөг маягтуудыг хөтлөх арга зүйгээр хангаж сургалт зохион байгуулсан.



Шинэ ажилтан нар нар хөтөлбөрийн хүрээнд эмч, сувилагч, тусгай мэргэжилтэнд хүний нөөц сургалт хөгжлийн алба, сувилахуйн алба, халдвар хяналтын алба хамтарч сургалтыг 2 удаа зохион байгуулсан.

Герман улсын Доктор, зүрх судасны ахлах, тэргүүлэх зэргийн эмч Доктор Ralp Schoeller нь нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй 2022 оны 09 сарын 23-ны өдөр ирж нийт 46 эмч нарт ажлын байрны сургалт, зөвлөгөө өгч ажиллана.



Герман улсын эмч нарын нийгэмлэгийн доктор ноён ПОП нь нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй ирж Төвлөрсөн ариутгалын тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай танилцан ариутгалын тоног төхөөрөмжүүдийг зориулалтын дагуу зөв ашиглаж байгаа талаар талархал илэрхийлж хамтран ажиллаж нийт 5 хүнийг герман улсад туршлага судлуулах талаар хэлэлцсэн




ГАДААД СУРГАЛТ /Өндөр хөгжилтэй оронд суралцуулан, туршлага судлуулах/

НИЙГМИЙН АРДЧИЛАЛ МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБООНЫ дэргэдэх SOCIAL HOUSE POLICY INSTITUTE болон Бүнмэй сургалтын төвтэй хамтран хэрэгжүүлж Япон улсын **Sasson Sugara Clinic** төвд сэргээн засах эмчилгээний чиглэлээр 2 сарын хугацаанд дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах сонгон шалгаруулалтанд тэнцсэн т бөгөөд сургалт 2022 оны 9 сарын 2-ноос 2 сарын хугацаатай суралцаж, сургалтын зардал, нислэгийн зардал зэргийг байгууллага шийдвэрлэн суралцууллаа.



Европын кардиологийн нийгэмлэгийн конгресст Зүрх судасны их эмч С.Байгалмаа нь 2022 оны 8-р сарын 23-наас 8-р сарын 30-ны хооронд Шенген улсад “Зүрхний дүрс оношилгоо” сэдвээр 7 хоног сургалтанд хамрагдсан.



Олон улсын Сонму эмнэлгийн үйл ажиллагаатай Эм зүйн албаны дарга О.Отгончимэг, Эм зүйч Б.Энхмаа нар ажлын байрны туршлага судлан ажиллан ирсэн.



Вьетнам улсанд “Хэвлийн диализ эмчилгээний үед зонхилон тохиолдох хүндрэлүүд түүний эмчилгээ, оншилгооны хяналт” сэдвээр 8 хоногийн ажлын байраны дагалдан сургалтанд хамрагдуулан туршлага судалсан.



Судалгаа шинжилгээ хийсэн:

НЭМГ -с 2022 оны 11сарын 16-18 зохион байгуулсан UB health care арга хэмжээд эрдэм шинжилгээний хуралд

- ✓ С.Байгальмаа Багануур гэмт хэргийн тохиолдолд шүүх магадлан шинжилгээ хийсэн
- ✓ Б.Халиун иргэдийн сайн дурын талаарх мэдлэг, хандлагыг сэдвээр
- ✓ Д.Мөнгөнцацрал Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн дэмжих үйлчилгээний албаны үйлчлэгч нарыг гүйцэтгэлээр цалинжуулах сэдвээр



дүүрэгт гарсан зарим сэтгэц, эмгэг судлалын дүн хепатитийн В вирусийн дархлаажуулалтын тодорхойлох нь

“Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн Томуу томуу төст өвчний үеийн уламжлалт сэргээн засах эмчилгээний үр дүнг тооцсон байдал”

Байгууллагын эрдмийн зөвлөлөөс зохион байгуулсан илтгэлийн уралдаанд оролцож 1 - р шатанд тэнцэж Монголын эмэгтэй инженерүүд, технологичид, эрдэмтэд, математикчдын нэгдсэн байгууллагаас зохион байгуулсан Эмэгтэй судлаач эрдэмтдийн шилдэг илтгэл шалгаруулах тэмцээнд оролцож эрхээ авсан байна.



Сайн туршлага 2022:

Жил бүр НЭМГгазраас зохион байгуулдаг “Сайн туршлага – 2022” арга хэмжээний удирдамжийн дагуу “Сайн туршлага-2022” арга хэмжээний анхан шатны шалгаруулалтыг байгууллага дотроо зохион байгуулсан. Үүнд:

№	Алба, тасаг, нэгж	Оролцсон бүтээлийн тоо
1	Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ гемодиализын тасаг	5
2	Дэмжих үйлчилгээний тасаг	3
3	Төрөх, нярайн тасаг	4
4	Нэгдсэн мэс заслын тасаг	17
5	Төрөлжсөн тусламж, үйлчилгээний тасаг	5
6	УАУСЗЭ-ний тасгийн	3
7	Нэгдсэн лабораторийн тасаг	1
8	Хүүхдийн тасгийн	3
9	Нийгмийн эрүүл мэндийн дэмжих төв	1
10	“Биваангирд” ӨЭМТ	7
Нийт		49

“Сайн туршлага-2022” арга хэмжээнд нийт шалгарсан 12 бүтээлийг шагнаж урамшуулсан. Үүнд:

- Эмчилгээний технологи номинацид шалгарсан 5 бүтээлийг үндсэн цалингийн 25%, батламж,
- Бусад 5 бүтээлийг үндсэн цалингийн 10%, батламж
- Биваангирд ӨЭМТ-ийг 100 мянган төгрөг, батламжаар шагнасан.
- Оролцсон бүх бүтээлүүдэд БАТЛАМЖ гардуулсан.

Анхан шатнаас шалгарсан 24 бүтээлийг нийслэлд зохион байгуулагдах “Сайн туршлага-2022” арга хэмжээнд хүргүүлсэн.

Нийслэл хотын 383 жилийн ойг угтсан “Сайн туршлага-2022” арга хэмжээнд манай байгууллага нь “Сайн туршлага-2022” арга хэмжээнд 39 байгууллагын 299 бүтээлүүдээс оношлогоо, эмчилгээний шилдэг бүтээлүүдээрээ 4 номинацид шагнал хүртэж Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудаас хамгийн олон шагнал хүртсэн байгууллагаар тодорч 1 бүтээл тэргүүн байр, 1 бүтээл тусгай байрын шагнал, 2 бүтээл сайн туршлагын санд бүртгэгдэж гэрчилгээ авлаа. Үүнд:



Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний технологи номинаци-ТЭРГҮҮН БАЙР:

“Гэмтэл, мэс заслын 9 төрлийн хагалгаа”-г шинээр нутагшуулсан сайн туршлага – Нэгдсэн мэс заслын тасгийн эмч Э.Од-Эрдэнэ



Шинээр нэвтрүүлсэн оношилгооны технологи номинаци-ТУСГАЙ БАЙР:

“Ходоодны архаг үрэвслийн киотогийн ангилал, киотогийн ангилалын дагуу ходоодны хорт хавдрын эрсдэлийн үнэлгээ хийх ба дурангийн хариуг бичиж тэмдэглэх” – НЭМДТ-ийн дурангийн эмч Ц. Чанцалдулам
Эхний шатанд шалгарсан нийт ажилчдад үндсэн цалингийн 10 хувь, тэргүүн болон тусгай байр эзэлсэн ажилчдад үндсэн цалингийн 25 хувийн урамшуулал олгосон.

Тогтвор сууршилтай ажиллуулах, нийгмийн хамгаалалын чиглэлээр:

Ажлын байрандах ажлын нөхцөлийг сайжруулах

1. Ажлын зохион байгуулалтыг оновчтой болгох



- Цалинтай болон тэтгэмжтэй олгодог чөлөөний хугацааг нэмэгдүүлэн 5-7 хоногоор олгосон.
- Хүний нөөцийн хүрэлцээ хангамж дутагдалтай үед урт хугацааны танхимын сургалтанд хамруулахаас илүүтэйгээр богино хугацааны ажлын байран дээрх дагалдан сургалт болон цахим хэлбэрийн сургалт нь илүү ач холбогдолтой байсан. Иймээс цахим хэлбэрээр явагдаж байгаа аливаа сургалтуудад холбогдох мэргэжилтнүүдийг заавал хамруулах, шаардлагатай мэргэжилүүдээс нэг

ажилтныг нь богино хугацааны танхимын сургалтанд хамруулж, суралцаж ирсэн ажилтан маань бусад ажилтнуудыг дагалдан сургах замаар богино хугацаанд олон ажилтныг чадавхижуулах арга хэмжээ авч байна.

- 2022 оныг Эрүүл мэндийн яамнаас "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах" жил болгон зарласны дагуу болон Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох зорилго бүхий "Цахим Монгол" арга хэмжээ, эрүүл мэндийн салбарт хийгдэж буй санхүүжилтийн шинэчлэл зэрэгтэй уялдуулан **"Цахим шилжилт –Цаасгүй эмнэлэг"** болох зорилтыг тавин ажилласан.

Үүний дагуу 2022.07.01-ний өдрөөс эхлэн МИТПС ХХК-ийн Medsoft v7 эмнэлгийн системд шилжин манай эмнэлэгийн дараах үйл ажиллагаанууд цахим хэлбэрт бүрэн шилжсэн. Үүнд:

- Амбулаторийн тусламж үйлчилгээ
- Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ
- Дүрс оношилгоо
- Лабораторийн тусламж үйлчилгээ
- Хагалгаа мэс заслын тусламж үйлчилгээ
- Сувилахуйн тусламж үйлчилгээ
- Цус сэлбэх тусламж үйлчилгээ
- Эмийн сан
- Яаралтай тусламж
- Түргэн тусламж



Үзлэг зөвлөгөөний цаг товлолтууд цахим болсон ба үйлчлүүлэгчид мсж хэлбэрээр болон цахим хэрэглэгчийн хуудас ашиглан мэдээллээ авна.

Оношилгоо шинжилгээний захиалга цахим хэлбэрт шилжсэн ба шинжилгээний хариу гарсан тохиолдолд Каллпро системээр дамжуулан мэдээлэл ирдэг ба үйлчлүүлэгч өөрийн шинжилгээ оношлогооны хариуг хэрэглэгчийн хуудсаар дамжуулан интернет орчинтой газраас хаанаас ч авах боломжтой болсон.

Лабораторийн шинжилгээний төхөөрөмжүүд системд бүрэн холбогдсон ба шинжилгээний хариуг төхөөрөмжөөс автоматаар илгээж хариу хэсэгт ордог.

Дүрс оношилгооны хариу болон холбогдох PACS зургууд үйлчлүүлэгчийн цахим түүхэнд хадгалагддаг болсон ба интернет орчинтой газраас хаанаас ч өөрийн мэдээллээ харах боломжтой.

Амбулаториор үзүүлсэн оношилгоо, шинжилгээ, үзлэгийн мэдээлэл цахим хэлбэрт бүрэн шилжиж ЭМД-ын журмын дагуу бодит цагийн горимоор цахимаар илгээдэг.

Хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ, үйлчлүүлэгчийн Өвчний түүх, Төрөлтийн түүх, Нярайн түүх Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/611 дүгээр тушаалын дагуу анхан шатны бичиг баримтууд цахим хэлбэрт шилжиж ЭМД-тай холбогдож мэдээллийг бодит цагийн горимоор солилцож байна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 177 тоот тушаалын дагуу Мэс заслын аюулгүй байдлыг бүртгэх хяналтын хуудас № 01, Мэс заслын сувилагчийн хяналтын хуудас № 02 (а), Мэс заслын сувилагчийн хяналтын хуудас № 02 (б) зэрэг, Мэдээгүйжүүлгийн зарлагын хяналтын хуудас № 03, Мэдээгүйжүүлгийн аппарат шалгах хяналтын хуудас №04 зэрэг хуудсуудыг цахим хэлбэрээр хөтөлж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Цахим шилжилт хийгдсэнээр иргэд бүх шатны эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхдээ дугаарлаж зогсохгүйгээр хуваарийн дагуу очоод шууд үзлэг оношилгоондоо хамрагддаг болох, Өөрийн үзүүлсэн эмчтэйгээ заавал очих шаардлагагүйгээр цахимаар харилцаж, дараа дараагийн заавар зөвлөгөөгөө авдаг болох, Эмнэлэгт бичиг цаас барьж гүйхгүй болсноор эмч сувилагчдын гар ажиллагаа, цаасан хэрэглээг бууруулж, цаг завьыг 3 дахин хэмнэх юм.

ҮР ДҮН:

Эмнэлгийн үйл ажиллагааны 90%, эмнэлгийн тусламж үйлчилгээний анхан шатны маягт 100% цахим хэлбэрт шилжин “Цахим шилжилт –Цаасгүй эмнэлэг” зорилтоо биелүүлэхийн зэрэгцээ:

- Тусламж үйлчилгээний стандарт мөрдөлт, хэрэгжүүлэлтийн хөтөч болж байна. /Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдлийн MNS 4621:2008 стандартаас 109 -ийг оруулан, программын тохиргоо хийгдсэн/
- Мэргэжилтэн бүр хийж буй ажлын гүйцэтгэл, үр ашиг, үр дүнг хянах боломжтой болсон.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөж буй журам, төлөвлөгөөний дагуу төлбөрийн үйлчилгээний түвшинг удирдана. Үйлчилгээний түвшинг тооцоолохдоо



төлбөрийг тасгийн, хүүхдийн, өндөр настны, шөнийн, яаралтай тусламжийн гэх мэт шаардлагатай бүхий л үзүүлэлтийг харгалзаж болно.

- Бүхий л шатны хяналтын хугацаа багассан. Хяналт 100% цахим болж, хянах хугацаа 2-3 дахин богиноссон.
- ЭМД-ын санхүүжилт, хасагдлын шалтгаан тодорхой болсон учир тухай бүр нь залруулга хийгддэг, хяналтын шалгуурын тусгай цонхтой.
- Байгууллагын үр ашиг, бүтээмжийг хянах шаардлагатай статистик үзүүлэлтүүдийг автоматаар тооцоолдог болсон зэрэг нь байгууллагын үйл ажиллагаа, эмчилгээ, оношлогоо, тусламж үйлчилгээний чанар үр дүнг удирдахад чухал үр дүнгээ өгч байна.
- 2021 оны 10-р сарын 17-ны өдрөөс Сувилахуйн албаны бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөнөөр 2022 онд үр дүнг үзэн бүр сайжруулан сувилагч нарын ажлын ачаалалыг үнэлэн, тэнцвэржүүлэн ажиллаа.

2. Тогтвор суурьшилтай ажиллуулах талаар авсан арга хэмжээ:

- Нэн шаардлагатай байгаа мэргэжлийн Нүүр амны их эмч Б.Золзаяа, Мэдээгүйжүүлэгийн их эмч А.Мягмар нарыг амьдрах нөхцөл, байраар үнэ төлбөргүй 100% ханган ажиллуулж байна.



- Тус Эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай мэргэжилтэн, орон байргүй, залуу гэр бүл болсон нийт 6 ажилтанд байрны урьдчилгаа болох хүн тус бүрт 20 сая төгрөг буюу нийт **120,000,000 сая төгрөгийг** олголоо.
 1. Төрөх тасгийн эрхлэгч эмч Батэрдэнийн Даваабаяр
 2. Халдвартын их эмч Цэрэннадмидын Батнаран
 3. Яаралтай тусламжийн их эмч Отгохбаатарбн Сүхбат
 4. Ренген техникч Нямдоржийн Янжиндулам
 5. Үйлчлэгч Баасанжавын Азжаргал
 6. Сүрьеэгийн их эмч Санжаажамцын Энхцэцэг нарт тус бүр 20 сая төгрөг буюу нийт **120,000,000 сая төгрөгийг орон байрны нөхцөл сайжруулах, орон нутагт 10 хүртэл жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлтэйгөөр олгосон. Мөн түрээслээд өмчлөх орон сууцанд** 2021 онд 5, 2022 онд 1 нийт 6 эмч, ажилтанд олгоод байна.



Дараах байгууллагад нэн шаардлагатай төрөлжсөн нарийн мэргэжил олгох сургалтанд байгууллагын 100%-ийн зардлаар сурган, шаардлагатай нарийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэсэн. Үүнд:

- Чимэдрэгзэн Мягмарсүрэн- Сэтгэл засал судлал
- Амгалбаатар Байгаль- Эх барих эмэгтэйчүүд судлал
- Батзориг Батзаяа- Хэвлийн хөндийн дурангийн мэс засал
- Самбуу Шинэжил- Аюултай хог хаягдлын ажилтан нарыг тус тус сургалтанд суралцуулан тогтвор суурьшилтай ажиллах боломжийг олгон ажиллаа.

Ажилчдын эрүүлжилт, үзлэг оношилгоо:

Нийт ажилтнуудыг 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулсан.Хамрагдалтын хувь 90,36%.

Томуугийн дархлаажуулалтанд нийт ажилтнуудын 57,1% нь хамрагдсан:

№	Албан тушаал	Хамрагдвал зохих хүний тоо	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь
1	Эмч	93	39	41,9%
2	Сувилагч	103	70	67,9%
3	Бусад	136	84	61,7%

2. Цалин мөнгө, мөнгөн урамшуулалыг нэмэгдүүлэх

- 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг үнэлэн 07 сараас эхлэн 12 сарыг дуустал хугацаанд бүх ажилтнуудад албан тушаалын үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдлийг сар бүр нийт 190 сая.төг
- Тасгийн эрхлэгч, албадын дарга нарын хариуцлагын нэмэгдлийг 40 хүртэл хувь болгон нэмэгдүүлсэн.
- 6 ажилтанд орон сууцны нөхцөл сайжруулах зорилгоор тус бүр 20 сая.төг нийт 120,0 сая.төг
- 2022 оны 11 сард “**ГҮЙЦЭТГЭЛИЙН УРАМШУУЛАЛ, 13 ДАХ САРЫН ЦАЛИН**” ажилтан бүрт сарын 200,000₮, жилийн 2,4 сая.төг

2022 онд гүйцэтгэлийн хүрээнд ур чадварын нэмэгдэл 20%, гүйцэтгэлийн урамшуулал 13 дах сарын цалин, орон сууцны нөхцөл сайжруулах зэрэгт нийт 1,2 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай, нарийн мэргэжлийн мэргэжилтнүүд болох

- 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг үнэлэн 07 сараас эхлэн 12 сарыг дуустал хугацаанд бүх ажилтнуудад албан тушаалын үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдлийг сар бүр олгож 2022 оны 11 сарын байдлаар **206,019,625 сая** төгрөг олгосон байна.
- 6 ажилтанд орон сууцны нөхцөл сайжруулах зорилгоор тус бүр 20 сая.төг нийт **120,000,000 сая.төгрөгийг** олгосон.
- 2022 оны 11 сарын 22-ны өдрийн Удирдлагын багийн хуралдаанаар дараах шалгуур хангасан байгууллагын ажилтан бүрт сарын 200,000₮, жилийн 2,4 сая.төгийг **“ГҮЙЦЭТГЭЛИЙН УРАМШУУЛАЛ, 13 ДАХ САРЫН ЦАЛИН”** болгон 11 сард олгохоор шийдвэрлэсний дагуу олгогдож нийт **654,999,806 сая төгрөгийг** олгосон байна

Шалгуур:

1. Байгууллагын орон тооны ажилтан байх
 2. 2022.10.01-ээс өмнө ажилд орсон байх
 3. Мэргэжлийн болон ёс зүйн ноцтой зөрчил гаргаагүй, сахилгын шийтгэлгүй байх, 2022 онд сахилгын шийтгэл авсан бол шийтгэлийн хугацаанд олгогдохгүй
 4. Жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй, урт богино хугацааны сургалтанд суралцаж байгаа болон суралцаж байгаад ирсэн, өндөр насны тэтгэвэрээ тогтоолгосон ажилтнуудад бодит ажилласан сараар тооцон олгоно.
 5. Ээлжийн амралттай сарыг ажилласанд тооцно.
 6. Сарын фонд цагийн 50 хувиас дээш хугацаанд ХЧТА-тай байсан, чөлөөтэй байсан бол тухайн сард олгогдохгүй
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоолын дагуу үндэслэн Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 03 сарын 24-ний өдрийн Б/87 тоот тушаалаар нийт 246 ажилтны цалинг нэмэгдүүлэн олгосон.
 - Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журмын дагуу 2022 оны 11 сарын байдлаар нийт **287,004,158 сая** төгрөгийг олгосон.
 - Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу Ур Чадварын нэмэгдэлийг нийт **71 ажилтан буюу 18,733,778** төгрөгийг олгосон.
 - 50 нас хүрсэн ажилчид нийт 13 эмч, сувилагч эмнэлгийн мэргэжилтэн нарт тус бүр 60000 мянган төгрөг нийт 780000 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
 - 2022 оны 08-р сарын 01-ний өдрөөс Тасгийн эрхлэгч эмч болон албаны дарга нарын хариуцлагын нэмэгдлийг нэмэгдүүлэн албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртлэх хувиар дүгнэн тооцон олгож байна.

- Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр 109.1 дэх заалт, 109,3 дах заалтийг үндэслэн илүү цагийг 1,8 дахин, шөнийн цагийг 1,2 дахин бодож олгож байна.
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт Хоолны мөнгө өдрийн 4000 төгрөг буюу **237,040,000 сая** төгрөг, унааны зардал өдрийн 1000 төгрөг буюу **26,932,000 сая** төгрөг тус тус олгосон байна.
- Байгууллагын дотоод журамд заасны дагуу ар гэрийн гачигдал гарсан 10 эмч, сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилт тус бүр 200000 төгрөгийг нийт 23 ажилтанд **4,450,000 төгрөг**, нас барсан ажилтны ар гэрт **2,221,857** Төгрөг нийт 6671857 **мянган төгрөгийн** буцалтгүй тусламжийг олгон нийт **920 цагийн цалинтай** чөлөө олгосон

3. Төрийн дээд шагнал, Эрүүл мэндийн яам болон бусад газрын шагналд тодорхойлон олголоо.

2022 он бол Багануур дүүргийн Эрүүл мэндийн салбар 44 жилийн түүхэнд **“ХОС ХҮНИЙ ГАВЪЯАТ ЭМЧ”-тэй болсон түүхэн жил байлаа.**

Монгол улсын Хүний Гавъяат эмч Л.Намжилсүрэн
Монгол улсын Хүний Гавъяат эмч Д.Цэрэндаваа



Тайлант хугацаанд нийт ажилтан шагнагдсанаас:

- ❖ Хүний гавъяат эмч-2
- ❖ Хөдөлмөрийн гавъяаны улаан тугын одон-2
- ❖ Алтангадас одонгоор-7
- ❖ Хөдөлмөрийн хүндэт медаль-5
- ❖ ЭМ салбарын 100 жилийн ойн медаль-25
- ❖ “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгээр –8
- ❖ ЭМЯ-ны “Жуух бичиг”-ээр -11
- ❖ НЭМГ-ын “Тэргүүний ажилтан” цол тэмдэгээр -12
- ❖ НЭМГ-ын “Өргөмжлөл”-өөр -20
- ❖ Дүүргийн ИТХ-ын “Өргөмжлөл”-өөр-14
- ❖ Дүүргийн ИТХ-ын “Хүндэт үнэмлэх”-ээр-5
- ❖ Дүүргийн Засаг даргын “Баярын бичиг”-ээр-9
- ❖ Дүүргийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр – 3 тус тус шагнагдаад байна.



2.2.1 Бусад

Олон улсын сувилагч нарын баярын өдөр:

МСН-ийн 25 жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй “СУВИЛАГЧ ЧАМДАА БАЯРЛАЛАА” тоглолтын 250 билетийг 100% дааж нийт ажилчид болон ахмад сувилагч, тусгай мэргэжилтнүүдээ урамшууллаа.

"Сувилагчдын бие даасан байдал, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулая" уриан дор Олон улсын сувилагчдийн өдрийг тэмдэглэн хүндэтгэлийн хурал зохион байгууллаа. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 19 гаруй сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг эрүүл мэндийн салбар, нийслэл, дүүргийн шагналаар шагнаж, урамшууллаа.



Олон улсын сувилагч

нарын баярын өдрийг тохиолдуулан зүүн бүсийн гурван дүүрэг болох Багануур, Багахангай, Налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч эмнэлгийн ажилчдын дунд зохиогдсон ТВ-Караоке нэвтрүүлэгт багаараа 2-р байр эзэлсэн амжилтаар оролцсон.



Эмнэлгийн ажилчдын баярын өдөр:

Эрүүлийг хамгаалахын ажилчдын баярыг угтаж, үйлчлэгч нарын дунд мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, холбогдох тушаал зааврын биелэлтийг сайжруулан, эмнэлгийн тусламж үйлчилгээний халдвар хамгаалал, ёс зүй, харьцаа хандлагын талаархи мэдлэгийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, багаар ажиллах чадварыг сайжруулах, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор “Ур чадварын уралдаан”-ыг зохион байгуулсан. Уралдаанд үйлчлэгчид 5 хүний бүрэлдэхүүнтэй багт хуваагдан 6 баг оролцсон. Уралдааныг 2 үе шаттайгаар явуулсан ба 2022 оны 07 сарын 29-нд онолын шалгалт, 08 сарын 6-нд ур Удирдамжийн дагуу:

ЭМС-ын 505,536,537, А/406 тоот тушаалуудаар 50 асуумж бүхий тестээр мэдлэг шалгахад 33 үйлчлэгч хамрагдаж 88,6%-ийн амжилттай үнэлэгдсэн.

Уралдаанд:

- Багийн мэндчилгээ, танилцуулга,
- Багийн гишүүдийн дунд 4 асуулттай, 1 бодлогтой даалгавар өгч түүний дагуу багаараа хариултыг өгөх,
- Гардан үйлдлээр ур чадвар сорих,
- Багийн ахлагч нарын дунд асуулт хариулт / ЭМС-ын 406 тоот тушаалаас,
- Гэрийн даалгавар. Баг бүхэн нэг бүлээлч ажил хийж танилцуулах. “Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх” гэсэн 5 чиглэлээр ур чадвараа сорьж оролцсон.

Баг тус бүр уралдаанд идэвхитэй оролцож, бүгд ажлын байрны тав тух, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх, тушаал зааврын хэрэгжилт, стандартыг мөрдөхөд чиглэсэн үр дүнтэй ажлуудыг өөрсдийн нөөц болмжинд тулгуурлан **630800₮**-өөр санаачлан хийсэн.



Удирдамжийн дагуу:

- 1-р байранд орсон багийн гишүүн Э.Энхтуяа, Н.Болортуяа, Д.Урантуяа, Н.Цагаанцэцэг, Б.Хишигням нарт нэг сар үндсэн цалингийн 25 %-иар ур чадварын нэмэгдэл,
- 2-р байранд орсон багийн гишүүн Г.Баясгалан, Л.Оюунчимэг, З.Оюунтунгалга, Д.Мандаалай, Б.Цэрэндулам нарт нэг сар үндсэн цалингийн 20%-иар ур чадварын нэмэгдэл
- 3-р байранд орсон багийн гишүүн Б.Азжаргал, Ж.Энхзаяа, Б.Оюунтөгс, Ж.Байгаль, Б.Базаррагчаа нарт нэг сар үндсэн цалингийн 15 %-иар ур чадварын нэмэгдэл олгохоор байгууллагын даргын тушаалыг Эмнэлгийн ажилчдын баярын хурал дээр танилцуулан, Байгууллагын даргын нэрэмжит шагнал, “Өргөмжлөл”-өөр шагнаж урамшуулав. Монгол улсын хэмжээнд зохион байгуулсан **“ИЛҮҮДЭЛ**

ЖИНГҮЙ – ЭРТЭЧ МОНГОЛ “ аяны хүрээнд 1 сар өглөө 07.20-07.40 хооронд дасгал хийж хэвшсэн.



Байгууллагын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн

Нийт ажилтан тасаг нэгжийн дунд байгууллагын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн Төрөх нярайн тасгийн хамт олон 1-р байр, 2-р байр УАУСЗЭ тасаг тус тус эзэлсэн байна.



Дэлхийн эмч нарын өдөр

Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан Баярын хурлын үйл ажиллагааны энэ үеэр дүүргийн Засаг даргын нэрэмжит “Алтан чагнуурын эзэн”-ээр: Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэгийн их эмч Оонойн Оюунчимэг Сэтгэц, наркологийн их эмч Сэнгэренчингийн Байгалмаа Эрүүл мэндийн яамны жуух бичгээр -4, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 2, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын “Өргөмжлөл”-өөр 4 эмч нар тус тус шагнагдлаа. УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очирын зүгээс ЭМТ-ийн эмч нар болох Ганбаатарын Батбаатар, Батзоригийн Батзаяа, Цогтсайханы Минсэл нарт талархал гардуулж, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан юм.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан НЭМГ-аас харьяа байгууллагынхаа эмнэлгийн ажилчдын хүүхдүүдийн дун "Миний хайртай гэр бүлийнхэн КОВИД-19" сэдвээр ЗОХИОН БИЧИГ, ГАР ЗУРГИЙН уралдаан зарлагдаж манай байгууллагын ажилчдийн хүүхдүүдийн 29 бүтээл оролцсон.

6-10 насны хүүхдүүдийн дундах Гар зургын уралдаанд 3-р байр Үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга Баатар-Уулын Анар 13-17 насны хүүхдүүдийн дундах Гар зургын уралдаанд 3-р байр Үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга Баатар-Уулын Эрхэмсайхан

13-17 насны хүүхдүүдийн дундах Гар зургын уралдаанд 3-р байр Сэрээн засах эмчилгээний их эмч Баяраа Цолмончимэг



Олон улсын эх хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ.

Төрөх нярайн тасгийн хамт олон **Олон улсын эх хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг** зохион байгуулах хөтөлбөрийг байгууллагын даргад танилцуулж хөтөлбөрийг батлуулсан.

ТЭМЦЭЭН УРАЛДААН.



Тус онд Эрүүл мэндийн төвийн хэмжээнд 18 ажилтанд 84 хоногийн цалинтай чөлөө, 39 ажилтан 189 хоногын цалингүй чөлөө олгосон байгаа нь өмнөх онтой харицуулвал буурсан үзүүлэлтэй байгаа нь эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын нийгмийн баталгааг анхааран ажиллаж буйн нэг илрэл юм.

Олон улсын сувилагч нарын баярын өдрийг тохиолдуулан зүүн бүсийн гурван дүүрэг болох Багануур, Багахангай, Налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч эмнэлгийн ажилчдын дунд зохиогдсон ТВ-Караоке нэвтрүүлэгт багаараа 2-р байр эзэлсэн амжилтаар оролцсон.

АЖИЛЧДЫН ГЭР БҮЛИЙН БАТ БӨХ БАЙДАЛ, АЖИЛТНЫ АЖЛЫГ ОЙЛГОХ, ГЭР БҮЛИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАТАН ОРОЛЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

ЭМТ-ийн залуучуудын зөвлөлөөс зохион байгуулсан “Хайраар болзоё” уулзалт өдөрлөгт нийт 15 залуу гэр бүлийг оролцуулан тасалбарын үнэ болох 1 хосын 50000 мянган төгрөгийг БНЭМТ-ийн Залуучуудын зөвлөл, тасаг нэгжүүд төлж оролцуулсан.



Сэтгэл засалч эмч лектер Далайцэрэнг урин Багануур Эрүүл мэндийн төвийн ажилчдын өсвөр насны хүүхдүүдийг хамруулан “Өсөр насны Сэтгэуийн эрүүл мэнд, IQ” сэдвээр сургалтыг амжилттай зохион байгуулан Эрүүл мэндийн ажилчдын хүүхдүүдийг баг болгон хуваан ажил арга хэмжээнд оролцон дуу хоолойгоор хүргэн ажиллахаар боллоо.





Ажилчдын бие бялдарыг чийрэгжүүлэх, хамт олны эв нэгдэлийг бэхжүүлэх, гэр бүлийн таатай орчинг бүрдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “ **Аз жаргалтай гэр бүл**” өдөрлөг тэмцээн зохион байгуулсан. Уг өдөрлөгт нийт 42 гэр бүл 32 хүүхэд оролцсон. Өдөрлөгөөр:

- Тасгийн үйл ажиллагаа, гэр бүлийн танилцуулга
- Гар бөмбөг
- Хөгжөөнт буухиа
- 3x3 сагсан бөмбөгийн тэмцээн явагдаж нийт **570000₮** зарцуулсан.



Ахмадын баяр тэмдэглэн өнгөрүүллээ.

Эрүүл мэндийн салбарын хөгжилд залуу халуун насаа зориулан уйгагүй хөдөлмөрлөж ихийг бүтээж, залуу хойч үеэ үлгэрлэн дагуулж яваа ахмад буурлууд хүлээн авч Ахмадын баяраа тэмдэглэн өнгөрүүллээ. Үйл ажиллагаанд 149 ахмадаас нийт 89 ахмад оролцож "Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан" цол тэмдэгээр Б.Бавуубадамыг шагнаж, нийт 80 дээш настай 9 ахмадад байгууллагын дарга хүндэтгэл үзүүллээ .



НЭМГ-ийн Харъяа эрүүл мэндийн байгууллагын дунд зохион байгуулагдсан спортын 5 төрөлт тэмцээн.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын спортын 5 төрөлт тэмцээнд Багануур дүүргийн эрүүл мэндийн төвийн тамирчид гар бөмбөгийн эмэгтэй баг тамирчид дэд байр, шилдэг довтлогчоор эх баригч Б.Чанцалдулам, сагсан бөмбөгийн эрэгтэй баг тамирчид гуравдугаар байр, эмэгтэй баг тамирчид тусгай байр, Ширээний теннис 4-р байр тус тус эзлэж нийт 23 байгууллагаас нийлбэр оноогоор 3-р байр эзлэн амжилттай оролцлоо.



